

МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

№01

Улаанбаатар хот

"Монгол Даатгал" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн заалтууд, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугар тогтоол болон 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн тогтоол №45 батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам" болон холбогдох хууль тогтоомжийн дагуу 2022 оны 4-р сарын 29-ний өдрийн 15:00 цагаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж 32, "Монгол даатгал" ХК-ийн байрны 3 давхарын хурлын танхимд хуралдав.

Хурлын дарга О.Цогт: "Монгол Даатгал" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож байгаа та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн эцнээ санал хураалтаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг компанийн тухай хуульд нийцүүлэн гаргасан. Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТУЗ-ийн гишүүн Б.Аюушийг томилсон боловч тус хурлыг удирдах боломжгүй болсон тул 2022 оны 4-р сарын 28-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Даргын тогтоолоор намайг хурлын даргаар томилсон болно. Хуралд ТУЗ-ийн гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн Л.Таня, ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал О.Эрдэнэбулган, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, тус хурлын комиссын дарга А.Санчирмаа, "Гендекс" ҮЦК ХХК-ийн Ч.Бат-Өлзий, Д.Дэлгэрмаа нар, Хувьцаа эзэмшигч Э.Золзаяа, Даатгалын хариуцсан захирал О.Гантөмөр, Үйл ажиллагаа хариуцсан захирал Б.Булган, Хууль, эрх зүй хариуцсан захирал Т.Наранцогт оролцож байна. Хурлын ирцийн бүртгэлийн дагуу хурлын ирцийг тогтоох болно. Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдэд харуулан саналын хайрцагийг нээнэ үү.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий саналын хайрцагийг нээж саналын хуудсыг тоолж ирцийн бүртгэлд оруулав. Хурлыг хүчин төгөлдөр болох тухай шийдвэр уншиж танилцуулна.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий: "Монгол Даатгал" ХК нь нийт 64,132,341 ширхэг хувьцаатай, үүнээс 109,239 ширхэг халаасны хувьцаатай буюу саналын эрхтэй 64,023,102 ширхэг хувьцаатай, саналын хайрцагнаас нийт 2 саналын хуудас гарлаа. Нийт 267 хувьцаа эзэмшигч байгаа. "Миллениум Секьюритис Менежмент Лимитед" компани 63,997,215 ширхэг хувьцаатай, Э.Золзаяа 154 ширхэг хувьцаатай байна. Нийт саналын эрхтэй 63,997,369 ширхэг хувьцаатай буюу 99,8 хувийн ирцтэй байна. "Компанийн тухай хууль"-ийн 69.1 дэх заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцох тухай Тооллогын комиссын анхдугаар тогтоолыг танилцуулья.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий тооллогын комиссын тогтоол №01-ийг уншиж танилцуулав.

Хурлын дарга О.Цогт: Хурлын ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцох ирц хүрсэн учраас хурлаа нээж, Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн тогтоол болон уг тогтоолоор баталсан хурлыг дэгийг танилцуулья.

ТУЗ-ийн тогтоолыг бүтнээр нь уншиж танилцуулна.

Хурлын дарга О.Цогт: Хурлаар хэлэлцэх асуудлуудын материалыг та бүхэнд хүргүүлсэн. Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудал бол "Монгол Даатгал" ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах юм. ТУЗ-ийн дүгнэлтийн тогтоолыг танилцуулья.

ТУЗ-ийн компанийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг танилцуулав.

Хурлын дарга О.Цогт: Монгол Даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус дүгнэлтийг гаргасан бөгөөд хувьцаа эзэмшигч та бүхэн баталж өгнө үү. 2022 оны 02 дугаар сарын 18-ны ТУЗ-ийн 22/07 Ногдол ашиг хуваариалхгүй тухай тогтоолын 2-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй шалтгааныг тайлбарлана уу хэмээн Гүйцэтгэх захирал О.Эрдэнэбулганг урьж байна.

2022 оны 02-р сарын 19-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн №22/07 тогтоолыг уншиж танилцуулав.

Гүйцэтгэх захирал О.Эрдэнэбулган: Тус шийдвэрийн дугаар 2-т 2022 оны 04 дүгээр сард хуралдах хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, шалтгааныг тайлбарлахыг миний биед үүрэг болгосон. Компанийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдал, эрсдэлийн түвшинг харгалзан үзэж 2021 оны ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар Төлөөлийн удирдах зөвлөл шийдсэн болно.

Хурлын дарга О.Цогт: Гүйцэтгэх захирал О.Эрдэнэбулган танд баярлалаа! Дараагийн хэлэлцэх асуудал бол Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай юм. Өнөөдрийг хүртэл хүчинтэй байгаа Төлөөлөн удирдах зөвлөл нь 2020 оны 4-р сард анх томилогдсон бөгөөд Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацаа нь 3 жил юм. ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны гишүүн, ТУЗ-ийн гишүүн Л.Таня таныг Нэр дэвшүүлэх хорооны шийдвэрийг танилцуулж, ТУЗ-ийн нэр дэвшигчдийг товч танилцуулахыг хүсье.

Нэр дэвшүүлэх хорооны гишүүн, ТУЗ-ийн гишүүн Л.Таня: Энэ өдрийн мэндийг хүргэе! ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо хуралдаж дараах 6 гишүүнийг ердийн гишүнээр, 4 гишүүнийг хараат бус гишүүнд нэр дэвшүүлэхээр тогтсон.

Л.Таня гишүүн бүх гишүүдийг товчоор танилцуулна.

Хурлын дарга О.Цогт: Л.Таня гишүүндээ баярлалаа! Дараагийн асуудал бол ТУЗ-ийн 2022 оны зардлын төсвийг батлах. Төсвийг та бүхэн дэлгэцээр мөн тараах материал дээр харж болно.

Хурлын дарга О.Цогт: Гүйцэтгэх захирал О.Эрдэнэбулган таныг компанийн дүрэмд оруулах өөчрөлтийг танилцуулна хэмээн урьж байна.

Гүйцэтгэх захирал О.Эрдэнэбулган товч танилцуулав.

Хурлын дарга О.Цогт: Хурлын дэгийн дагуу та бүхэнд хэлэлцэж буй асуудлуудтай холбогдсон асуулт байна уу?

Хуралд оролцогчдоос асуулт гарсангүй.

Хурлын дарга О.Цогт: Та бүхэнд хурлаад гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт байна уу?

Хуралд оролцогчдоос асуулт гарсангүй.

Хурлын дарга О.Цогт: Хуралд оролцогчдоос асуулт гараагүй учир хурлаа үргэлжлүүлэн тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий санал тоолох ажилд зориулан цаг өгөх үү?

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий: Саналын тоолох ажил дууслаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын дүн дараах байдалтай байна. Нийт 63,997,369 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид саналаа өгч хэлэлцсэн бүх асуудлаар 100 хувийн саналаар зөвшөөрсөн байна. Татгалзсан санал байхгүй тул баталсанд тооцов.

Тооллогын комиссын дарга Ч.Бат-Өлзий тооллогын комиссын тогтоол №02, 03-ыг уншиж танилцуулав.

Хурлын дарга О.Цогт: Тооллогын комисс шийдвэрээ танилцууллаа. Үүнийг үндэслэж хурлаас гарах шийдвэрүүдийг танилцуулья.

Нэгдүгээр асуудлаар: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн "Монгол Даатгал" ХК-ийн 2020 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

Хоёрдугаар асуудлаар: Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.

Дараах 6 нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгосугай:

1. Огай Н.Ю.
2. Громов С.Б.
3. О.Эрдэнэбулган
4. Л.Таня
5. С.Тэнгис
6. Громов Б.С.

Дараах 3 нэр дэвшигчийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгосугай:

1. О.Цогт
2. Б.Аюуш
3. Б.Энхтуяа


Компанийн эрх ашгийг дээдлэн, Компанийн тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

Гуравдугаар асуудлаар: "Монгол даатгал" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг хавсралт №01-ээр баталсугай. Батлагдсан төсвийг мөрдөн, ТУЗ-ийн үйл

ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

Дөрөвдүгээр асуудлаар: Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1, болон 7.22 дах хэсэгт өөрчлөлт оруулж, 7.52 дах хэсэг 7.52.1, 7.52.2, 7.52.3 заалтууд, 7.53, 7.54, 7.55 хэсгийг хавсралтад зааснаар нэмэж оруулсугай. Дүрмийн нэмэлт өөрчлөлтийг Улсын бүртгэлд бүртгүүлэхийг Хууль, эрх зүй хариуцсан захирал /Т.Наранцогт/-д даалгасугай.

Хурал 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16:07 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:  А.Санчирмаа

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА:  О.Цогт